



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/2023

Мандалговь

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай 01 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтад орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэхээр батлагдсан “Хүүхэд түр хамгаалах байр /тоног төхөөрөмж” ажлын гүйцэтгэгчээр “Зууны гүүр” ХХК шалгарсан тул 248,437,455 (хоёр зуун дөчин найман сая дөрвөн зуун гучин долоон мянга дөрвөн зуун тавин тав) төгрөгөөр тус ажлын гэрээг байгуулсугай.

2. Батлагдсан техникийн тодорхойлолтын дагуу “Хүүхэд түр хамгаалах байр /тоног төхөөрөмж” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Зууны гүүр” ХХК (Х.Дэлгэрмаа)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай байгуулсан гэрээнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100719